



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, дахин үнэлсэн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй, 13 нэрийн, нийт 32,348,412.14 (гучин хоёр сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун арван хоёр төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа Д.Батчулуун, харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн хамт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007600
4-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
С.А. Дугаар тогтоолын хавсралт

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он (дахин үнэлсэн)	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2023 оны 449 дүгээр тогтоолд заасан доод үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдаж байгууллагын дансанд төвлөрүүлэх доод үнэ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгаа байгууллагын нэр
1	"Авеко"дизель 55-91 УНТ	2012/ 2019	1,500,000.00	1,300,000.00	500,000.00	ЦЕГ-ын харьяа автобааз
2	"Киа опирус" 01-60 УБИ	2010/ 2022	6,000,000.00	3,000,000.00	500,000.00	ЦЕГ-ын харьяа автобааз
3	УАЗ-22069 82-66 УБЕ	2008/ 2022	1,314,000.00	5,000,000.00	1,000,000.00	ЦЕГ-ын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар анги
4	Хьюндай элентра 02-70 УБУ	2011/ 2022	1,460,625.00	5,000,000.00	1,000,000.00	ЦЕГ-ын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар анги
5	ПАЗ-32053 40-19 УБУ	2011/ 2022	1,957,499.99	5,000,000.00	1,000,000.00	ЦЕГ-ын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар анги
6	Мотоцикл /om 150-3j/ дугааргүй	2011	3,323,255.43	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
7	Мотоцикл /om 150-3j/ дугааргүй	2011	3,323,256.43	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
8	Мотоцикл /om 150-3j/ дугааргүй	2011	3,323,257.43	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба

9	Мотоцикл /от 150-3j/ дугааргүй	2011	3,323,258.43	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
10	Мотоцикл /от 150-3j/ дугааргүй	2011	3,323,259.43	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
11	Мотоцикл /дугааргүй/	2010	1,050,000.00	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
12	Мотоцикл /дугааргүй/	2010	1,050,000.00	100,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
13	Мотоцикл /Мустанг Police/ дугааргүй	2010	1,400,000.00	900,000.00	0.00	ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба
	Нийт дүн		32,348,412.14 (гучин хоёр сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун арван хоёр төгрөг арван дөрвөн мөнгө)		4,000,000.00 (дөрвөн сая)	